



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2020 он 12 дугаар  
сарын 11-ны өдөр

Дугаар 208/2929

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанд бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн хийх мэдээллийг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000020516062



**БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, СУРГУУЛЬ,  
ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДАЛТЫН БАЙДАЛ, ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫГ ЦАХИМ  
ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД  
ЕРӨНХИЙ САЙДЫН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтээс шалтгаалж дэлхий нийтээрээ хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоож, энэхүү цар тахлыг хохирол багатайгаар даван туулахын тулд улс орон бүр хичээж, нөөц боломжоо бүрэн дайчилж байгаа энэ үед Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос тодорхой шийдвэрүүдийг хугацаа алдалгүй, шуурхай гаргаж, шаардлагатай бүхий л зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Бүх шатны сургалтын байгууллагын орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хорио, хөдөлгөөний хязгаарлалтын дараа хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх, хэвийн горимд шилжүүлэх бэлтгэлийг хангаснаар 2020-2021 оны хичээлийн жилд бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг эхлүүлсэн билээ. Гэсэн хэдий ч 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тул танхимын сургалтыг түр зогсоож, теле болон цахим хэлбэрээр хичээл, сургалтын үйл ажиллагааг үргэлжлүүлж байна.


2020-2021 оны хичээлийн жилд боловсролын салбарын нийт 2,281 байгууллагад 97,132 багш, ажилтан ажиллаж, сургуулийн өмнөх, бага болон дунд, дээд боловсролын үйлчилгээг нэг сая хүүхэд, залуучуудад үзүүлж байна.

Нэг. Сургуулийн өмнөх боловсрол:

2020-2021 оны хичээлийн жилд 1,454 цэцэрлэгт 247,040 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшин, 30,668 багш, ажилтан ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт урьдчилсан байдлаар 79.8 хувьтай<sup>1</sup> байгаа нь өмнөх оноос 4.8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Дэлхий нийтээр тархсан халдварт цар тахлаас сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын үед эцэг эх, асран хамгаалагчдын болгоомжлол зэрэг нь хамран сургалтад нөлөөлж байна.

*Зураг. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид (хичээлийн жил)*



<sup>1</sup> Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2019 оны суурин хүн амын тоог төлөвлөн тооцсон болно.



### Хүртээмжийг нэмэгдүүлэх талаар:

- 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23,075 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга шинээр барих, өргөтгөх 163 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна;
- Энэ хичээлийн жилд Улаанбаатар хотод 3,370 хүүхдийн хүчин чадалтай 19 цэцэрлэг, орон нутагт 3,100 хүүхдийн хүчин чадалтай 31 цэцэрлэг, нийт 6,470 хүүхдийн хүчин чадалтай 50 цэцэрлэг ашиглалтад орлоо. Одоогоор 113 цэцэрлэгийн барилга угсралтын ажил үргэлжилж байна;
- Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд 5 цэцэрлэгийн өргөтгөл, мөн АНУ-ын Элчин сайдын яамны санхүүжилтээр орон нутагт 4 цэцэрлэгийн барилга угсралтын ажил явагдаж байна;
- НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 2 цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүллээ.

### Хоёр. Ерөнхий боловсрол:

2020-2021 оны хичээлийн жилд нийт 739 сургуульд 686 мянган хүүхэд (өдрөөр 680.8 мянга, орой, эчнээгээр 144, дүйцсэн хөтөлбөрөөр 5,340) суралцаж, 54,498 багш, ажилтан ажиллаж байна.

Энэ хичээлийн жилд 4 сургуульд нийт 8 бүлгийн 251 хүүхэд гуравдугаар ээлжээр хичээллэж байна.

Суралцагчдын сурч боловсрох эрхийн баталгааг хангах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад бүх талаар анхаарч байгаа хэдий ч хүн амын хурдацтай өсөлт, шилжилт хөдөлгөөн, барилгын насжилт өндөр, ашиглалтын хугацаа дууссан зэрэг шалтгаанаас үүдэн сургуулийн суудлыг нэмэгдүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

Тухайлбал, ерөнхий боловсролын хүүхдийн тоо 2024 онд 800 мянга, 2030 онд 900 мянга болж өсөх төлөвтэй байгаа тул улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах орчин нөхцөлийг хангахад чиглүүлэх шаардлагатай байна.

#### 2.1. Дотуур байрны хүртээмж:

Хичээлийн жилийн эхний байдлаар ерөнхий боловсролын сургуулийн 540 дотуур байранд 35,000 сурагч амьдарч байсан бөгөөд сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан дотуур байрны бүх хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

#### 2.2. Сурах бичгийн хүртээмж:

2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд I-XII ангийн нийт 137 нэр төрлийн сурах бичиг хэрэглэгдэж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр дунд, ахлах ангийн 98 нэрийн 2,735,030 ширхэг сурах бичгийг хэвлэн сургуулийн номын санд нийлүүлж дунд, ахлах ангийн сурагчдын 60 хувийг сурах бичиг төлбөртэйгээр ашиглуулах



үйлчилгээнд хамруулсан. Сурах бичгийн жилийн турш ашиглах төлбөрийн хэмжээ 1,700-21,000 төгрөгийн хооронд байна.

Түрээсийн тогтолцоог хэрэгжүүлж, эргэлтийн санг бүрдүүлснээр улсын төсвөөс сурах бичигт зарцуулах зардал хэмнэгдэж, дунд, ахлах ангийн бүх сурагч багц сурах бичгээр хангагдах, сурах бичиг худалдан авах зардал буурах, сургалтын чанар, орчин сайжрах зэрэг олон талын ач холбогдолтой байна. Түүнчлэн сурах бичгийн эргэн хуримтлалын санг үүсгэн, сурах бичиг хэвлэх хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, сурах бичгийн үнийг бууруулах, хүртээмжийг дээшлүүлэх бололцоог бий болгож байна.

Гурав. Дээд боловсрол:

2020-2021 оны хичээлийн жилд 88 дээд боловсролын сургалтын байгууллагад 11,966 багш, ажилтан ажиллаж, нийт 146,722 оюутан суралцаж байна.

Нийт суралцагчдын 82,896 буюу 56.5 хувь нь нийтийн өмчийн сургуульд, 56,923 буюу 38.8 хувь нь төрийн бус өмчийн сургуульд, 197 буюу 0.1 хувь нь гадаадын салбар сургуульд суралцаж байна.

*Хүснэгт. Суралцагчдын тоо (сургуулийн өмчийн хэлбэрээр)*

Хичээлийн жил	Суралцагчид (сургуулийн өмчийн хэлбэрээр)			
	Бүгд	төрийн	хувийн	гадаадын салбар сургууль
2016-2017	157,138	91,798	65,075	265
2017-2018	155,248	89,473	65,628	147
2018-2019	157,625	87,992	69,370	263
2019-2020	148,446	82,901	65,355	190
2020-2021	146,722	82,896	56,923	197

Нийт суралцагчдын 138,237 буюу 93.8 хувь нь Улаанбаатар хотод суралцаж байгаа бөгөөд эдгээр суралцагчдын 66,934 буюу 48.4 хувь нь орон нутгийн харьяалалтай суралцагч байна.

Цар тахлын онцгой нөхцөл байдалтай уялдуулж орон нутгийн оюутнуудыг шинжилгээнд хамруулан орон нутагт нь буцаах ажлыг зохион байгуулж байна. 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар нийт 2795 оюутныг ар гэрт нь буцаасан бөгөөд энэ ажил үргэлжилж байна.

2020 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийслэлийн 56 оюутны дотуур байранд 8804, орон нутгийн 15 оюутны дотуур байранд 1338 оюутан тус тус амьдарч байна.

Их, дээд сургуулиуд өөрийн санхүүжилтээр дотуур байранд амьдарч байгаа оюутнуудад 131.1 сая төгрөгийн хоол хүнс, эм, ариутгалын бодис зэрэг нэн хэрэгцээ шаардлагатай байгаа зүйлсээр хангажээ.

Дотуур байрны оюутнуудын явсан маршрутыг тодорхойлж, шууд болон дам хавьтлын шинжийг тандах асуумж бэлтгэн их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулж байна.



Орон нутагт болон Налайх дүүрэгт байгаа их, дээд сургуулийн дотуур байранд амьдарч байгаа оюутнуудыг тухайн орон нутгийн эрүүл мэндийн төвд коронавирусын шинжилгээнд хамруулсан бөгөөд шинжилгээний хариу бүгд “сөрөг” гарчээ.

#### Дөрөв. Цахим сургалт:

Монгол Улсын Засгийн газраас сургалтын хөтөлбөрт суурилсан боловсролын үйлчилгээний /суралцахуйн/ тасралтгүй байдлыг хангах зорилгоор олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хичээл, сургалтын үйл ажиллагааг мэдээллийн технологи ашиглан зайн болон цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Зайн болон цахим сургалт нь тэгш боломж, тэгш хамруулалтыг хангахад чиглэгдэж байгаа бөгөөд сургалтын үр нөлөөг сайжруулах үүднээс технологийн болон сургалтын агуулгын бэлэн байдал, эцэг эх, олон нийтийн дэмжлэг, хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэгийн хичээлийн хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилийн төгсгөлд теле хэлбэрээр нөхөн олгосон. Энэ хугацаанд нийт 4,485 теле хичээлийг бэлтгэж, 16 телевизийн сувгаар дамжуулан суралцагчдад хүргэснээс гадна эдгээр хичээлүүдийг [www.econtent.edu.mn](http://www.econtent.edu.mn) цахим хуудсанд байршуулснаар суралцагчдыг хүссэн үедээ нөхөж болон давтан үзэх боломжоор хангасан.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр теле хичээлийн хүртээмж, үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн. Тус үнэлгээгээр нийт суралцагчдын 16 орчим хувь нь теле хичээлээ үзэж чадаагүй байна<sup>2</sup>. Теле хичээлийн хүртээмж хамгийн бага хүрсэн сурагчид нь малчин, төв сууринаас алслагдсан, орлогын түвшин доогуур болон эцэг, эхийн анхаарал халамж сул өрхийн хүүхдүүд байна.

Теле хичээлийг хүлээн авч буй гол хэрэгсэл нь телевиз (78.3 хувь), гар утас (49 хувь) байна. Сургуулийн өмнөх ба бага, дунд ангийнхан телевизээр теле хичээлээ голчлон үзэж байсан бол ахлах ангийнхан гар утсаа түлхүү ашиглаж байна гэжээ.

2020-2021 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрт тохиргоо хийж, шинэ хичээлийн жилийн эхэнд бататгах, сэргээн санах, давтах агуулга, арга зүй, аргачлалыг бэлтгэн, багш нарт нэгдсэн заавар, зөвлөмж өгч ажилласнаас гадна шинээр 10,520 минутын 33 цагийн хичээлийг бэлтгэн Боловсролын хүрээлэнгийн баталсан хуваарийн дагуу багш, суралцагчдад хүргэж байна.

Теле хичээлийг дохионы хэлбэрээр хөрвүүлэх, тэгш хамруулан сургах, тусгай хэрэгцээ, шаардлагатай хүүхдэд зориулсан хичээл явуулах, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, төгсөх ангийн сурагчид болон олон нийтэд зориулсан насан туршийн боловсролыг дэмжих хичээлүүдийг нэмсэн болно.

Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 78.8 мянган хүүхэд элсэн суралцаж байгаа бөгөөд эдгээр хүүхдэд зориулсан сургалтын гарын авлага, зөвлөмж, дасгал, даалгаврын дэвтрийг хүргүүлэн бэлтгэлийг хангаснаас гадна багш, эцэг эхийн хамтын ажиллагааг дэмжсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

<sup>2</sup> “Онцгой байдлын үеийн теле хичээл түүний үр дүн, тохиромжтой байдал судалгааны тайлан” БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, IRIM судалгааны хүрээлэн. Улаанбаатар хот, 2020 он.



Цахим сургалтыг үр дүнтэй болгох зорилгоор аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газраас теле хичээл, цахим сургалтыг хүүхэд бүрд хүрч буй эсэхэд хяналт тавьж, багш нарт зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг удирдан зохион байгуулж байна.

Теле хичээл үзэх техникийн боломж гэр бүлийн орчинд нь бүрдээгүй цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын суралцагчдад хичээлийн агуулгыг бүрэн хүргэх, тэднийг сургууль завсардахаас сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг орон нутгийн боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Теле хичээл, цахим сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад эцэг эх, олон нийтийн оролцоо дэмжлэг чухал. Нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын телевизүүдийн холбоо, Монголын үүрэн холбооны бүх компани хамтран ажиллаж байна.

2019-2020 оны хичээлийн жилийн хоёрдугаар улиралд их, дээд сургууль, коллежиуд цахим сургалтын технологийг ашиглан сургалтын үйл ажиллагаагаа явуулсан. Цахим сургалтын үйл ажиллагаанд сургуулиудын зүгээс нийт нөлөөлөх хүчин зүйлийг оруулан 86 сургуулийн оюутнаас сэтгэл ханамжийн судалгаа авахад 82.5 хувь нь сургалтын хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн, сэтгэл ханамжтай гэсэн байна.

Оюутнуудын сэтгэл ханамжийг авч үзвэл:

- Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын оюутны 85 хувь;
- Төрийн бус өмчийн дээд боловсролын байгууллагын оюутны 84 хувь;
- Гадаадын дээд боловсролын байгууллагын оюутны 78 хувь нь сэтгэл ханамжтай гэж гарсан байна. Иймд эдгээр судалгаанд үндэслэн интерактив, цахим сургалтын платформ үүсгэн хичээлийн үр дүнг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр үргэлжлүүлж, 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн улирлын амралтад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ хугацаанд теле хичээлийг тасралтгүй зохион байгуулж, төлөвлөгдсөн бүх агуулгыг бүрэн олгохоор төлөвлөсөн болно.

Цаашид дэлхий нийтийг хамарсан аюулт цар тахлын үед сургалтын үйл ажиллагааг хэвийн, хүртээмжтэй явуулах бодлогын хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирал буюу 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг танхимын, танхимын болон танхимын бус хосолмол, зайн болон цахим хэлбэрээр явуулах бодлого баримтлан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мөн гэртээ радио, телевиз, интернэтэд холбогдох боломжгүй суралцагчдад хэвлэмэл сургалтын материал, оффлайн агуулгыг дамжуулах, гар утасны мессеж ашиглан мэдээлэл өгөх зэргээр мэдээллийн технологийн энгийн хувилбаруудыг боловсруулан туршиж, бага орлоготой гэр бүлд дэмжлэг үзүүлэх, дижитал төхөөрөмжөөр хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

-----oOo-----